



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ



“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК
УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАВСРАЛТ - 1

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, СТРАТЕГИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ (2024 - 2050)

Улаанбаатар хот
2024 он

НЭГ. ЗОРИЛГО

2007 оны 07-р сарын 05-ны өдөр батлагдсан “Төмөр замын тээврийн тухай” хуулийн 6-р зүйлд “Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулна...” гэж заасны дагуу 2008 оны 03-р сарын 05-ны өдөр Засгийн Газрын 82 дугаар тогтоолоор “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийг байгуулсан.

2010 онд Монгол Улсын Их Хурал 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд Монгол Улсад шинээр 6600 гаруй километр төмөр замыг 3 үе шаттайгаар барьж байгуулахаар тусгасан юм. Энэхүү бодлогын үр дүнд бий болох төмөр замын суурь бүтцийг өмчлөх аж ахуйн нэгж нь “Монголын Төмөр Зам” ТӨХК байна.

“Монголын Төмөр Зам” ТӨХК нь шинээр байгуулагдах төмөр замын суурь бүтцийн ирээдүйн өмчлөгч болохын хувьд төмөр замын аливаа бүтээн байгуулалтад анхнаас нь идэвх санаачилгатай, өөриймсгөөр оролцох нь зүйн хэрэг юм.

Иймд тус компанийн хөгжлийн үе шатыг тодорхойлж, тэдгээр үе шат бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг сайтар судалж, боловсруулах зайлшгүй шаардлагатай. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2024-2050 оны урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд компанийн үндсэн чиглэл, үзэл баримтлал, төлөвлөлтийн суурь, бизнес хөгжлийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлох үүднээс энэхүү баримт бичгийг боловсруулав.